

Д.Равжаа “Дөрвөн улирал” шүлэг

Хавар. Өсөх цаг

Эсэргэн хавар цагийн дохио ирэхэд
Эгшиглэн донгодогч олон шувуу жиргэлдэн
Ээлжлэх цагийн эргэлтийг мартаад
Эгүүрд байгаа хэлбэртэй байдаг л

—

Энхрийлэн өсгөсөн аав ээжийн хайранд
Эрхэлж өссөн жаргалдаа ташуурч
Элдэв наадам тохууныг даган явсаар
Эргээд ирэх дөрвөн далайн жамыг эс мэдэв л.

Зун. Идэр цаг

Жаргалтай дэлгэр зуныхаа гурван сард
Жигдлэн ургасан таван өнгийн бадам найгалзаад
Жигүүртэн олон шувуу нуурын дунд цэнгэхэд
Жавартай өвлийн хүйтнийг мартана л

—

Захирч сургагчдын сургаалыг орхиод
Зальхай найман номыг даган явсаар
Завдлага үгүй дөрвөн далайн
Жамыг эс мэдэв л.

Намар. Өтлөх цаг

Намрын хонгор салхи ирэхэд
Навч цэцгийн дуртмал өнгө нь сулраад
Найгалзах олон цэцгийн үр жимс нь автаад
Нарны дулаан илч нь буурна л.

—

Найртай багын омгоор
Найдангийн таван хорын эрхэнд хучигдаж
Найман чөлөөт хүний биеийг олсноон
Насны идрийн цогоор нөгцөөв л.

Өвөл. Өнгөрөх цаг

Хөхөө өвлийн дохио ирэхэд
Хөвчийн өндөр дээгүүр нь цас будраад
Хүйтэн жаварлагч салхины эрчим чангараад
Хөвчин дэлхийн өнгө буурна л.

—

Хүний биеийн шүтээн улмаар
Хөгшрөөд өтлөхийн хэрд
Хүч ба оюун билиг сулран хомстож
Хүчтэй үйл эрхийг дагана л.

Амраглан ханилсан амь бие хоёрыг
Аюултай эрлэгийн элчийг салгахын урьд
Ачит лам багшийг дагаж
Ариун нирвааныг олох болтугай.

(1803-1853)

Д.Нацагдорж "Дөрвөн цаг" шүлэг

Хавар

Мөнх тэнгэрийн доор мянга мянган хавар
Монголын сайхан орон дор жил жил дэлгэр
Энх улирал ханхлах дор хүний сэтгэл тэнэгэр
Өвсний соёо ногоорох дор морь мал ханагар
Холхи нар ойртож хасын цас хайлах дор
Хуучин дэлхий халагдаж хамаг юм шинэднэ
Хөхөрсөн мод цэцэглэж хүүхэд багачууд наадах дор
Хөгшин хүн өөрийгөө залуу болсон шиг санана
Хээрийн галуу айлчлан ирж, гангар гунгар донгодохуйяа
Гэртээ суусан малчин түүнийг чагнан уярна
Хажуу дахь ууланд горхи булаг хоржигнон урсахуйяа
Хаяан дахь ишиг хурга майлалдан, хөгжим нийлүүлнэ
Эелдэг урьхан амьсгал ариухнаар үнэртээд
Эрт эдүгээг бодогдуулан, нуугдсан сэтгэлийг сэргээнэ
Өнөр сайхан төл баян хотыг чимэхүй дор
Өлгийтэй бяцхан хүүхэд эцэг эхээ баясгана.

Зун

Цагийн сайхан зуны эхэнд
Газрын сайхан хангайн нуруунаа
Хөхөө шувуу урьхнаа донгодох үес
Энэхүү дэлхий юутай сайхан тааламжтай
Ногооны униар огторгуй тулж зэрэглэн мяралзахуйяа
Хүлэг морь урт янцгааж төрсөн нутгийг зүглэнэ
Цэцгийн хур дэлхийн нүүрийг угаах дор
Залуу хүмүүсийн сэтгэл сэргэж, бие биесээ бодно
Үзэсгэлэнт уул, тунгалаг ус зуны цаг дор тэгш
Эрийн гурван наадам монголын манлай баясгалан
Хүүхэд багачуудын гийнгоолох дуу хөндий тал дор яруу
Хурдан морины яралзан ирэх нь хүн бүхний бахдал
Уудам тал дор наадам цэнгэлийн аялгуу зөөлнөөр цуурайтна
Хээр хөдөө дор таван хошуу мал дураар сүлжин цэнгэнэ
Өрх бүрийн үүднээ айраг найрын үнэр сэнгэнэнэ
Ийнхүү сайхан ба баясгалантай, тийнхүү сайхан жаргалтай.

Намар

Намрын шар нар над дээр, чам дээр тусна
Найган найгах улиралд нь бид бас найгана
Буга хандгай урамдаж, уул усыг баясгах дор
Үхэр шар мөөрөлдөн малчин хүнийг зугаацуулна
Сайхан огторгуйн дунд нимгэн цагаан үүл нүүх дор
Идэр залуус алс газрыг сонирхон, сурахаар одно
Тунгалаг мөрөн зөөлөн зөөлнөөр дув дуугүй урсах дор
Түүний дотроо саран мишээж, янагийн үлгэрийг сэмээр өгүүлнэ
Өглөөний хяруу сувдын адил гилтгэнэн бууралтахуйяа
Гадаа сойсон морь бөн бөн чичирнэ
Гэрийн эзэн эртлэн, үнэг чоныг гөрөөлөхөөр одохуйяа
Эхнэр хүүхэд аарц нэрж, түүнийг хүлээнэ
Урьхан хонгор салхи өвс модыг намилзуулах дор
Хөгшин залуу хүмүүсийн сэтгэл бөн бөн бөмбөрнө
Шарласан модны навч хоёр нэгээ унах дор
Сэтгэлийн доторх уйтгарт явдал хааяа хааяа бодогдоно.

Өвөл

Алсын салхи жихүүхэн амьсгалаар тас няс хийхүй дор
Алтан дэлхийн уул тал мөнгөн хуягийг өмсөнө
Өвлийн шөнө тэнгэрийн одод оч мэт гялалзахуйяа
Уудам тал дор жинчин хүний дуулах яруу
Өндөр уулын оройд будан хүдэн зугаацаад
Өргөн талын хөндий нүд гялбам мэлцийхүй дор
Бэлчээр дор гарсан малууд соргог үсийг гялалзуулан буцах дор
Идэр залуу малчин түүнийг хураан исгэрнэ
Өндөр газрын хүйтэн тэсгэм тэсгэм, ясгим ясгим
Монголын залуус нүүртээ цогтой, нүдэндээ галтай
Зургаан мичид орой дээр, зулын гэрэл хажуу дор
Хөгшид өвгөд галыг базаан, хуучин үгсийг ярилцана
Өвөл, хавар, зун, намар дөрвөн улирал
Уул, усан, наран, саран лугаа нөхөрлөнө
Хүн бүр өтгөсийг үдэж, нялхсыг утган
Мянга мянган жил өчүүхэн ч чөлөө завгүй
1935 он

В. Инжинаш “Сэрүүн намар” шүлэг

Сэрүүн намар гуайг мөрөөдөх шөнө
Сиймхий цонхноо жигүүн салхи нэвт
Сийрэг хулсны навч хийсэх үед
Сэлгүүн хүн унтсан болов уу, үгүй үү?

Биндэрьяа огторгуйд, үүлгүй өглөө эрт сэрүүн
Бялхмал нуурт навч унаж усны хуниар бидэртэй
Бялзуухайн дууны хамт сонстох аялгууг эрэн чагнавал
Бяцхан шивэгчин билиг төрөөд бичиг унших эгшиг

Намрын салхи цэлэмгэр жигүүн үед
Найгах өвс хийсэн хийсэн уярна.
Навчийн улаанд шүлэг бичсэн мэт
Найрт зузаан хүнээ гомдоно.

Б.Галсансүх “Постмодерн дөрвөн улирал”

1.Намар

Охин тэнгэр Янжинлхамын онгон биесийг
Орцны өмнө нарлаж суугаа өвгөн найрагчид
Араас нь урдаас нь даанч гамгүй хэрэглэж хэрэглэхээд
\Аймаар эмгэн болгоод/ дараа үедээ өгөхөөс
Ичих шиг ийм нэг улаа бутарсан намар
Ирлээ. Гурван нар гарч газар дэлхийг
Исэлдэж гашилтал нь эдэж муудтал
Ээрч мууртал, эцэж хорчийтол
Элэгдэж хаттал нь шарсан юм шиг болгон
Хүрэхийн төдийд хэмхрээд, хиншүү хярвас ханхлаад
Хүрээгүй байхад нь хуурч, холцроод халцраад
Тайвшруулах эм уучихсан хэн нэгэн
Толгойгоо ширээн дээр тавиад хөнжилдөө
Шургаад цаг мартсан юм шиг
Шал утгагүй намар айлд зочлоод
Шал согтуу шалчганаад харихгүй суух гийчин шиг
Зовлонтой. Гал шаргал намар гадаа ирээд

Зөндөө удаан гунганахад гадсаа тойрох
 Ботгонууд шиг навчис модоо бараадад шуухитнана
 \ Ботго + Навч хоёрыг байгалийн өнгө холбоно \
 Баян намар бухал хийж, үтрэм дээр будаагаа цайруулаад
 Будаагаа “хуурай”-лаад жимсээ хураагаад
 Жигнэмгээ хайраад, жигүүртнээ дагуулаад
 “Жаахан шарга”-аа унаж, “Уяхан замбуутив”-ийн наран дор
 Найр хурим үймүүлж, агсам тавиад эсгийд боолгуулж
 Нам унаад нэмж уугаад нэгмөсөн тасраад
 \Уртын дуунд ухаан алдаж\ унь тооно зүүдлэн
 \Утгагүй зүүд\ унтах найрчин шиг налайсаар назгайрсаар
 Буцлаа. Нэг л өдөр. А.Вивальдийн намар шиг
 Биш юм. Ай миний намар. “Мөстлөгийн өмнөх үеийн”
 Маш жижигхэн тасархай энэ намар \ маш жижигхэн тасархай\
 Мэнд амар буцлаа. Мөнх хөх тэнгэртээ...

2.Өвөл

Зүүн,баруун,урд,хойд,ар,өвөр
 Зөв,буруу,суга,толгой,хөлний
 Хажуугаар зөвхөн өвөл л үйл явдлууд
 Хэмх, эмх замбараагүй холхилдон
 Үйл хөдөлгөөн, хэм хэмжээ амьдралын
 Үнэмшил, утга учир алдагдаж халтиргаа
 Гулгаа,хүч,таталцал,түлхэлцэл,цагаан
 Гялбаа,улаантуяа, хөх цайвар өнгө л өвлийг
 Тодорхойлно. \Төлөөлнө ч гэж бас хэлж болно\
 Тэгээд гэртээ бүгж шар бөмбөлөг шиг хүүхэдтэйгээ
 Тоглоно. Өвөл ор дэр л ихэнхдээ бодогдож
 Тулалдах гэж байгаа юм шиг бээлий, малгай
 \ Дайнд явах гэж байгаа юм шиг\ дах, ороолт гээд
 Дэмий ч юм шиг, дэмий биш ч юм шиг эд зүйлст
 Дэндүү их санаа зовно. \Анхаарал тавина\
 Дандаа өвөл болохыг дассан газраасаа холдож чадахгүйгээс
 Голын тунгалаг мөсөнд дүрсээ харах дуртайгаас
 Гал тогоондоо хоол хийх нь \гадаа даарснаас\
 Гоё санагдаж \ихэсдгээс ч гэж хэлж болно\
 Галаа түлж кофены үнэрийг үнэлж
 Зэрэглэж, дугаарлаж, таашааж, таашал авч
 \Зуныг дурсах нь анзаарагдамгүйгээр, алгуурхан
 Зугуухан, зогсолтгүйгээр, зориудын бусаао ихсэж\
 Зэрэглээ, баян бүрд, ойн төгөл, хээр талыг
 Хэн нэгний уланд чихрах цасны шаржигнаатай хутгах
 Хэвтэртээ хамаг биеэрээ тарааж түгээж
 \Салхины сэвшээ, сэрчигнээг хүртэл\ зүүдэлнэ.
 Салхийг зүүдэлж болдгийн учрыг бодоод бодоод бүү мэд
 Өвөл бид хоёрын аль нэг амьд үлдэх ёстой юм шиг
 \Өс хонзон үнэндээ байхгүй л дээ\ тийм аймаар хүйтэн
 Олсон зүйрлэлдээ баясаж \адилтгал ч гэж хэлж болно\
 Орондоо орно. Өвлийг өвөртөө оруулбал өвчин авна.

3.Хавар

Нүдэн нуурын тэртээд хусан төгөл цайраад
 Нарсан ойн гүнээс давирхайн үнэр ханхлаад
 Намар унасан боргоцой \салхины аясаар\
 Наашаа цаашаа бөмбөрөхөд ханатлаа
 Хөдөлсөн хүмүүн \хаврын үйлдээ эцээд
 Хар нүдээ хамхиж ч чадахгүй ядармуу. Зүсэр зүсэр

Намирах хавар эртийн борооноор зөөлөн гал дээр
 Нуугих сүүтэй цайгаа уудалж урд уулнаа
 Донгодох хөхөөн дууг санагалзаж уур хөөрч даргилах
 Данхтай цайгаа аягалмуу. Ханцуй мөр
 Нялх борооноос наашлах цагийн тухай
 Чухал мэдээллийг олмуу. Голын тэртээд
 Шаагилдах мэлхийн дууг сонсоод гадаа зогсоход даарах
 Шуугиангүй, тогтуун насаа бас голмуу. Улангассан
 Улаан сарыг үзээд урдуур хойгуур сэвэлзэх
 Уужим салхи ногоон өнгөтэйг мэдмүү. Тэр
 Саран хөөрөх тусмаа цайраад мөнгөн утас шиг
 Сарны гэрлэн хээг би тасалгаан дотроо
 \Гарынхаа хоёр алганы хооронд\ хөөцөлдүүлэн наадаж
 Гоё сайхнаар зугаацмуу. Сая төрсөн гөрөөсний янзага
 Урд намрын сул өвснөө бөмбөлзтөл чичрээд
 Уран гоо биетэй эхийнхээ элгэнд наалдан чинэсэн
 Хөхийг нь амирлуулж нудчин нудчин дулаацахыг
 Хамрын сэвэлзүүр шөнөөр бас мэдэрмүү. Гурван
 Нуурын тэртээд ангир нугас нуг нуг
 Дуугарахад усны чимээ гармуу. Дув
 Дуугүй нүүх хүнд хөх үүлийг хараад
 Хаврын аадар нижигнэх нь дээ гэж бодмуу. Халуун
 Хөнжилдөө шургаж хэсэг дугхийгээд босоход Урд
 Уулыг ороож манан буусан баймуу. Даруй түргэн
 Урин зуныг мөрөөдөхөд хаврын бороо довжоон дээр тог тог дусалмуу.

4.Зун

Агаар хэмжигч гучин долоон хэм дээр тогтож
 Агаарт царцааны сүрэг амьсгаадан нисэхэд
 Цар цар гэх дуу нь салхи үүсгэхэд \цочтол, цочтол\
 Цаг агаарын мэдээ мөрөн голын ус
 Савнаасаа хальсан тухай давтаж мөндөртэй аадраас
 Сэрэмжлүүлнэ. Хэн нэгэн үл таних хүн
 Хувь заяанд чинь санаа зовж төөрөг заяа
 Хувь тавилан, зурсан зургийг чинь зурхайч шиг
 Зун л ихэвчлэн хэлнэ. Зугаатай. Аянга цахилгаанаас
 Зугтах тухай зөвлөгөө өгнө. Зөв л дөө
 Хот тэр чигээрээ зун хоосорч цаг араарын мэдээг
 \Хэн ч сонсоогүй юм шиг\ эсэргүүцэж байгаа юм шиг
 Зуслан руу, гол руу, амралт руу, хээр тал руу
 Зугтана. Хөшөө дурсгал л хотод үлдсэн юм шиг
 Хүн амьтан эрс цөөрч хэрээ болоод болжморын тоо толгой
 Харьцангуй ихсэж тогоруу газар цөмрөх вий гэж алхахыг
 Тоншуул ойд түг түг мод цөмлөхийг хүүхдүүдээ харуулж
 Танин мэдэхүйн хичээл заана. Таатайхан. Амьдрахын
 Төлөө ажиллаж байгаагаа зун л мэднэ. Аз жаргалтай
 Тэгээд ажиллах хэрэгтэй гэж бодоод л ядарна. Ядаргаанд
 Ямар юм сайн бэ? Гэж асууцгаагаад янз янзын юм
 Ядартлаа ууна. Ядрах шалтгаан эндээс эхэлнэ.
 Зун загасчилж зогсоход зовлонгоо мартана. Жаргалаа ч гэсэн
 Зовлон шиг мартана. Зөвхөн загас өгөөш үмхэх
 Тухай тухтай бодож эгээд ертөнцөөс тасарч
 Тунгалаг устай уусаж \нэгдэж\ нэг бие болсноо мэднэ. Зунд
 Намраас, өвлөөс, хавраас илүү дуртайгаа, зуслан руу нүүх
 Наадам үзэх, найранд уригдсанаа \хожим нь\
 Энд тэндгүй явахдаа эрхгүй санана. Эргээд л зун чам руу ирнэ.
 Эсвэл чи зун руу очно. Элсэн дээр хэвтэж биеэ шарна.

Сүүдэр бараадаж дэвүүр бариад салхи хөгжөөнө. Сүрэг
Сүрэг уул цаашаа наашаа бэлчихийг ажиж шүүрс алдана.

2008.11.28

